# ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс/

2024 он

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.** /“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны статеги төлөвлөгөө/ | | | | | | | |
| **Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | | |
| 1.1 | Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | - | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо | 33245 | 39000 | Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Тоон гарын үсгийн талаарх” сургалтыг 10 төрийн болон төрийн бус байгууллагын 450 гаруй албан хаагчдад хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Нийт 39935 иргэнд тоон гарын үсэг олгосон нь 16 ба түүнээс дээш насны иргэдийн 75 хувийг эзэлж байна. /Өссөн дүнгээр/ | 100 |
| 1.2 | Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх | - | Үйлчилгээний авсан иргэдийн тоо | 4920 | 5250 | Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машинаар нийт 11843 иргэн /Гэрлэлт, Эд хөрөнгийн, Байнга оршин суугаа хаягийн, Цахим үнэмлэхний, Эд хөрөнгөтэй эсэх гэх мэт/ лавлагаа үйлчилгээг авсан.<br>Мөн 22963 иргэн улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр хураамж төлсөн.<br>“ГАДААД ПАСПОРТ ЗАХИАЛГЫН ЦАХИМ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | МАШИН"-аар 512 иргэн гадаад паспорт захиалсан. | |
| 1.3 | Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх | - | Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо | 0 | 1 | Хэлтсийн албан хаагчдын бүртгэлийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж ажлын ачааллыг тодорхойлсон.<br>Дүн шинжилгээний дагуу Баянтүмэн, Цагаан-Овоо сумын улсын бүртгэгч нарыг ажлын ачаалал тэнцвэржүүлэх зорилгоор хэлтсийн нэг цэгийн үйлчилгээнд 7 хоногийн 2 өдөр ажлуулж байна.<br>Мөн 6 суманд хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг олгож 141 бүртгэл хийгдсэнээр хэлтсийн бүртгэгч нарын ачааллыг тодорхой түвшинд бууруулсан. | 100 |
| 1.4 | Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санал хүргүүлэх | - | Холбогдох дүрэм, журамд хүргүүлсэн саналын тоо | 5 | 6 | "Өргөдөл, гомдол, санал, мэдэгдлийг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих, тайлан гаргах" зааврын төсөлд 2024.11.08-ны өдрийн 19/693 тоотоор УБЕГазрын ТГазарт санал хүргүүлсэн. | 100 |
| | | | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилгааны тоо | 5 | 6 | АЗДТГазрын Хууль эрх зүйн хэлтсээс 14 сумын ЗДТГазартай хамтран зохион байгуулсан "Иргэдийн эрх зүйн боловсрол"-д нээлттэй өдөрлөгт сумдын улсын бүртгэгч нар оролцож Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хууль дүрэм журмын хүрээнд нийт 588 иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан.<br>УБЕГ-ын цахим хуудсанд байршсан бодлого шийдвэр, хууль тогтоомжтой холбоотой мэдээллийг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт, www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк /8869 дагагчтай/ хуудсаар дамжуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтмол сурталчлан ажилласан. | |
| 1.5 | Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх | - | Мэдээ мэдээлэл, сурталчилгаа, контентын тоо | 6 | 10 | Бүртгэлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах зорилгоор Улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор "**ИРГЭН ТАНЫ МЭДЛЭГТ**" видео контент бэлтгэн байгууллагын цахим хуудас www.dornod.burtgel.gov.mn сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд цувралаар хүргэж ажилласан.Үүнд:<br>1.Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн талаарх мэдээлэл /үзэлт 783/<br>2.Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаарх мэдээлэл /үзэлт 1000/<br>3.Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогссон талаарх мэдээлэл /үзэлт 1400/<br>4.Хоршоо шинээр бүртгүүлэх бүртгэлийн талаарх мэдээлэл /үзэлт 4400/<br>5.Та үүнийг мэдэх үү? цуврал контент /6ш /үзэлт 27300/<br>6.Бүртгэлийн Гарт - Гэрт үйлчилгээ /үзэлт 5300/ хүн тус тус үзэж, 146 хүн бусдад хуваалцаж сурталчилсан. | 100 |
| **Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Төрийн болон төрийн бус байгууллагын туслам ж дэмжл | Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 45 | 100 | Дашбалбар, Халхгол сумдад зөөврийн тоног төхөөрөмж ашиглан цахим гадаад паспорт захиалах 800 иргэний материал хүлээн авч ажилласан. | 100 |
| | | | Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр зорилтот | 15 | 30 | Тайлант хугацаанд иргэний үнэмлэх шинээр /16 нас/ болон 25, 45 насны сунгалт, үндэсний энгийн гадаад паспорт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эг | бүлэгт үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | | | захиалхад өөрийн биеэр ирэх боломжгүй 8 иргэнд зөөврийн төхөөрөмж ашиглан бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажилласан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран зөөврийн төхөөрөмжөөр иргэний бүртгэлийн үйлчилгээ, тоон гарын үсэг 12 иргэнд олгосон. | 100 |
| 2.2 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг сурталчлах | - | Зохион байгуулалтын арга хэмжээний тоо | 17 | 20 | “E-business.mn”-ээр дамжуулан 1445 иргэнд хуулийн этгээдийн нэр баталгаажуулалтын болон цахим гэрчилгээний үйлчилгээг үзүүлж ажилласан.<br>“E-mongolia”-д ирүүлсэн иргэний шилжилт хөдөлгөөний 1132 бүртгэлийн хүсэлт хүлээн авч баталгаажуулсан.<br>Үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон УБЕГ-ын цахим хуудсанд байршсан цахим үйлчилгээ /e-Mongolia-н үйлчилгээ, E-business.mn, Цахим гадаад паспорт, Шилжилт хөдөлгөөний бүртгэл/ улсын бүртгэлийн хууль тогтоомжтой холбоотой 78 шторк, цаг үе, үйл явдалтай холбоотой 314 мэдээллийг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт, www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк /8869 дагагчтай/ хуудсаар тогтмол сурталчилж цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 96 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан. | 100 |
| | | | Цахимаар үзүүлсэн улсын бүртгэлийн тоо | 1370 | 1800 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia, E-business/ -аар жилийн эцсийн байдлаар тус аймгийн хэмжээнд 1445 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж ажилласан. | |
| 2.3 | Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх | - | Иргэний улсын бүртгэл хөтөлсөн тоо, хувь | 28060 /100%/ | 100% | 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 16347, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 820, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 9241 бүртгэлийг хууль дүрэм журмын дагуу хөтөлж ажилласан. | 100 |
| | | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоо, хувь | 1051 /100%/ | 100% | | |
| | | | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо, хувь | 8861 /100%/ | 100% | | |
| 2.4 | Иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэлийн хувийн хэрэг, нотлох баримт цахимжуулах | - | Цахимжуулсан хувийн хэргийн тоо | 254 | 400 | Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд ХУБ-ийн 2023 оны 4865 дүгнэлтээр нэмэлт өөрчлөлтөөр 422, нөхөн бүртгэл -102, ХУБ-ийн 2021 оны 6839 дүгнэлтээр 98 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулж ажилласан. ХШГазрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн №1500 дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 120 хувийн хэргийн цахим мэдээллийн санг архивын хувийн хэргийн цаасан нотлох баримттай тулган шалгаж мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулж, мэдээлийн санд баяжилт хийж ажиллав. | 100 |
| 2.5 | Улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Цахим архивын санд иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэлийн 573 ботийн 3120 хуудас эх нотлох баримт бичгийг цахимжуулсан. | 100 |
| 2.6 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын | Орон нутгий | Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 1040 | 1300 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/16 дугаартай захирамжаар батлагдсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021 оны 7/09 дүгээр тогтоолоор батлагдсан сумдын хүн амд үйлчлэх “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” төсөл арга хэмжээний хүрээнд сумдад улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах явуулын үйлчилгээг үзүүлэх | н төсөв | | | | хөдөөгийн хүн амд “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-г үзүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчид бүртгэлийн үйлчилгээг 13 сумын иргэдэд үзүүлж ажиллав. Сумдад ажиллах хугацаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хууль дүрэм журмын хүрээнд нийт 2100 иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч 120 гэрчилгээг гаргаж өмчлөгчид хүлээлгэн өгч ажилласан.<br>Мөн цахим гадаад паспорт захиалах 800 материал хүлээн авч ажилласан. | |
| 2.7 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих, ажлыг сайжруулах | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2024 онд иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 42 хүсэлт, талархал, өргөдөл, гомдлыг хүлээн авч 97.6% шийдвэрлэсэн. Үүнд:<br>Чулуунхороот сумын улсын бүртгэгчид 1 /Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой/ гомдол ирснийг улсын бүртгэгчээс тайлбар гаргуулан авч сонсох ажиллагааны шатанд явж байна./<br>Иргэний улсын бүртгэлийн тасагт 1 /Үрчлэлтийн бүртгэл мэдээллийн санд ороогүй байна гэсэн гомдлыг шийдвэрлэсэн./<br>Санхүүтэй холбоотой буцаалт хийлгэх 40 өргөдлийг шийдвэрлэсэн.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал тутамд УБЕГазар болон аймгийн ЗДТГазарт хугацаанд нь хүргүүлсэн. Хугацаа хоцорсон өргөдөл, | 97.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гомдол байхгүй. | |
| 2.8 | Иргэдийн санал хүсэлтийг сонсох 98-970-970 утас болон цахимаар зөвлөгөө мэдэээлэл хүргэх, сурталчилах | - | Зөвлөгөө мэдээлэл авсан иргэний тоо | 814 | 1000 | Иргэдийн санал хүсэлтийг сонсох 98-970-970 утасны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 1 албан хаагчийг 7 хоног хариуцан ажиллуулах хуваарь гарган ажиллаж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1085 иргэнд /Цахим гадаад паспорт, Тоон гарын үсэг, Шилжилт хөдөлгөөн, Хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт, Хоршоо байгуулах, Эд хөрөнгийн лавлагаа олголт, бүрдүүлбэр, бусад/ зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав. Үүнээс ИУБ-651, ЭХЭУБ-180, ХЭУБ-209, архив болон бусад-45 чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 2.9 | Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах | - | “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо | 6 | 10 | Аймгийн ЗДТГазр болон Булган, Хөлөнбуйр, Чулуунхороот, Халхгол сумдын ЗДТГазартай хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2024 оны 04, 05, 09, 10 дугаар саруудад нийт 6 удаа зохион байгуулж ажилласан.<br>Мөн Монголын хуульчдын холбооноос жил болгон зохион байгуулдаг “Хуульчийн ПроБоно өдөр-2024” өдөрлөгт оролцсон. Уг нээлттэй хаалганы өдөрлөгүүдээр нийт 185 иргэнд тоон гарын үсэг олгож, 840 иргэн, 26 аж ахуйн нэгжид Улсын бүртгэлийн байгууллагын бодлого шийдвэр, үйл ажиллагаа, цахим гадаад паспорт захиалах, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ, Хоршоо шинээр байгуулах, хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалт, E-business.mn, E-mongolia үйлчилгээг сурталчилж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан.<br>УБЕГ-ын цахим хуудсанд байршсан бодлого шийдвэр, цахим үйлчилгээ /e-Mongolia-н үйлчилгээ, Цахим гадаад паспорт, Тоон гарын үсэг, Хөдөлгөөний бүртгэл/, улсын бүртгэлийн хууль тогтоомжтой холбоотой 78 шторк, цаг үе, үйл явдалтай холбоотой 314 мэдээллийг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт, www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк /8869 дагагчтай/ хуудсаар дамжуулан тогтмол сурталчлан ажилласан. | |
| 2.10 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь гүйцэтгэж, үр дүнг мэдээлэх | - | Үүрэг даалгаврын биелэлт хүргүүлсэн тоо | 13 | 16 | УБЕГазрын шуурхай хуралдааны тэмдэглэл 19, даргын дэргэдэх зөвлөлийн 5 үүрэг даалгаврын биелэлтийг гарган хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг хангаж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах | - | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь. | 100 | 100 | Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 486 иргэн, 6 хуулийн этгээдийн нийт 492 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж торгох шийтгэл оногдуулан 13.735.000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан.<br>Мөн 2024 оны Монгол Улсын Их Хурлын, АНСДИТХурлын ээлжит сонгуультай холбогдуулан иргэний улсын бүртгэлийн шилжилт хөдөлгөөний нийт 3086 бүртгэлийг эх нотлох баримттай тулган шалгахад 18 иргэний бүртгэлд зөрчил илэрч улсын бүртгэгчдээр зөрчлийг арилгуулан ажиллалаа.<br>Шалгалт хийсэн болон илэрсэн зөрчлийг арилгасан илтгэх хуудсыг 2024.05.03-ны өдөр УБЕГазрын ХШГазарт цахимаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн.<br>Зөрчлийн тухай хууль, шилжилт хөдөлгөөний бүртгэлд цаашид анхаарах асуудлуудын талаар улсын бүртгэгч нарт 3 удаа заавар зөвлөмж хүргүүлэн ажилласан. | |
| 3.2 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх | - | Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо | 157 | 157 | Тайлант хугацаанд www.info.shilendans.gov.mn, болон хэлтсийн www.dornod.burtgel.gov.mn сайтад 139 мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. | 100 |
| | | | Тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн | 1.657.031.319 | 1.800.000.000 | Шилэн дансны бүртгэлд 904.600.140.62 төгрөг тайлагнасан. | 100 |
| 3.3 | Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх | - | Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь. | 100 | 100 | 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас "**ӨӨРЧЛӨЛТГҮЙ**" дүгнэлттэй үнэлэгдсэн. | 100 |
| 3.4 | Үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах | - | Мэдээг хугацаанд нь хүргүүлсэн тоо | 12 | 12 | 2024 оны үнэт цаас зарцуулалтын тайланг 11 удаа УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтэст хугацаанд хүргүүлэв.<br>2024 оны бараа материал худалдан авах зорилгоор 8 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан, худалдан авалтад 7.310.525 төгрөгийг зарцуулж ажилласан. | 100 |
| 3.5 | Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах | - | Тайлант хугацаанд эрсдлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнасан тоо | 2 | 2 | Хэлтсийн 2024 оны эрсдлийн төлөвлөгөөг боловсруулан баталсан.<br>УБЕГазрын 2024 оны үйл ажиллагааны эрсдэлийн төлөвлөгөө болон хэлтсийн 2024 оны эрсдлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарган УБЕГазрын БТДШГазарт хүргүүлсэн. | |
| 3.6 | Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд тайлан мэдээ хүргүүлэх | - | Зохион байгуулалтын арга хэмжээний тоо | 1 | 1 | Хэлтсийн албан хаагчдаас нууцын баталгааг шинэчлэн гаргуулж авсан.<br>Монгол Улсын Их Хурлын болон АНСДИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад нууцтай харьцан ажиллах зөвшөөрлийг хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 03/330, 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/576 тоот албан бичгээр тагнуулын байгууллагад хүргүүлсэн.<br>Мөн шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн албан хаагч нарт төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулж ажилласан.<br>Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн тайланг хуулийн хугацаанд УБЕГазрын Тамгын газар болон аймгийн Тагнуулын газарт хүргүүлж ажиллав. | 100 |
| 3.7 | Мэдээллийн санг ашиглаж буй албан хаагчдын компьютерт хортой кодын эсрэг хамгаалах программ суулгуулах судалгаа хүргүүлэх | - | Судалгаа хүргүүлсэн тоо | 0 | 1 | Хэлтсийн албан хаагчдын ашиглаж байгаа компьютерт вирусын программ суулгах судалгааг 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 19/687 тоотоор УБЕГазрын МТГазарт хүргүүлсэн. | 100 |
| | | | Хортой кодын эсрэг хамгаалах программ суулгуулсан компьютерын тоо | 0 | 29 | УБЕГазрын МТГазраас албан хаагчдын компьютерт хортой кодын эсрэг хамгаалах программыг нэгдсэн байдлаар суулгах талаар мэдээлэл технологийн ажилтанд мэдэгдсэн. | 100 |
| 3.8 | Сервер, сүлжээний тоног төхөөрөмжийн эд ангид засвар үйлчилгээг хийж | - | Хэвийн үйл ажиллагааг хангах засвар үйлчилгээний тоо | 34 | 40 | Баянтүмэн, Гурванзагал сумдын сүлжээний тоног төхөөрөмжийн эд ангид гарсан гэмтлийг тогтоож, сүлжээг хэвийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэх | | | | | үйл ажиллагаанд оруулж ажиллав. Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч нарын компьютер, тоног төхөөрмжид 42 удаагийн засвар үйлчилгээг /компьютер формат, Хуурний хээ уншигчийн алдаа, зургийн аппарат, онлайн программын түүл/ хийж хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан. | |
| 3.9 | Хэлтсийн 2024 оны зорилтот жилийн төлөвлөгөө боловсруулж, батлах | - | Зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2024 оны зорилтот жилийг "Хуулийн хэрэгжилт, Хамтын ажиллагаа" болгон тодорхойлж 2 бүлэг 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан баталсан. 2024 оны 03 дугаар сарын 13, 2024 оны 05 дугаар сарын 22, 2024 оны 08 дугээр сарын 23, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд тус тус "Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам"-ын дагуу шалгалтад оролцогч иргэдийн бүртгэлийг хуруууны хээгээр бүртгэж ажиллалаа. Аймгийн Засаг даргад төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай компьютер тоног төхөөрөмжийн судалгаа саналыг хүргүүлснээр компьютер, сканнер, принтер зэрэг тоног төхөөрөмжүүдийг шийдвэрлүүлсэн. | 100 |
| **Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 4.1 | МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хантан ажиллах. | Улсын төсөв | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан хэлтсийн 5 бүлэг 29 заалт бүхий дэд төлөвлөгөөг боловсруулан, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг хантан ажиллаж байна. Төлөвлөгөөний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу:<br>• МУИХ-ын сонгуулийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалтыг иргэний улсын бүртгэгч нарт 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан.<br>• Ерөнхий төлөвлөгөөний 24, 26, 27 дугаар арга хэмжээний хүрээнд тус аймгийн сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан 14 сумын ИТХ-ын тогтоолыг эх хувиар нь хуулийн хугацаанд нь хүлээн авч, сонгуулийн election.gasr.mn программд цахимжуулж оруулсан.<br>• Тус аймгийн 14 сумын 75 сонгуулийн хэсэгт хамаарах 14930 хаягийн мэдээллийг 14 сумын ИТХТТ-той тулган, нягтлан шалгаж хэсэг оноолтыг шалгасан.<br>• УБЕГ-аас 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/4924 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоосон.<br>• Тус аймгийн СНЖ-д төлөв оноогдсон 3014 сонгогчийн мэдээллийг нягтлан шалгасан. Дээрх хийсэн ажлуудын илтгэх хуудсыг тухай бүрт нь холбогдох газруудад нь хугацаанд нь хүргүүлж ажилласан.<br>• МУИХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн санал авах ажиллагааг 2024 оны 06 дугаар сарын 28-ний өдрийн 07:00 цагт эхлүүлж, 22:00 минутад зогсоов.<br>• Сонгуулийн ирц бүртгэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоног төхөөрөмжийг 2024.06.28-2024.07.02 өдрүүдэд аймгийн Тагнуулын байранд түр байлгаж байгаад 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр УБЕГ-т хүлээлгэж өгсөн. | |
| 4.2 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах | Улсын төсөв | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | АНСДИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан ИТХ-ын тогтоолыг эх хувиар 14 сумаас хүлээн авч, сонгуулийн election.gasr.mn программд цахимжуулж оруулсан.<br>УБЕГ-ын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/9869 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоосон.<br>АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн санал авах ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 07:00 цагт эхлүүлж, 20:00 минутад зогсоов. Дорнод аймгийн 14 сумын 75 хэсэгт үндсэн сонгогч - 50 974, нийт - 51 157 сонгогч бүртгэгдснээс санал өгсөн сонгогчийн тоо 30 696 буюу ирц 60 хувьтай байв.<br>Санал тэнцсэн хэсэгт нэмэлт санал хураалт 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Булган сумын 9-5-3 хэсэгт, 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Хэрлэн сумын 9-1-13 дугаар хэсэгт тус тус амжилттай явагдаж дууссан.<br>Сонгуулийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг 2024.10.11-2024.10.14 өдрүүдэд аймгийн Тагнуулын байранд түр байлгаж байгаад 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УБЕГ-т хүлээлгэж өгсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5. Хамтын ажиллагааг өргөжүүлнэ.** | | | | | | | |
| 4.1 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх. | ADB төсөл | Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн сумдын тоо | 1 | 2 | УБЕГазрын даргын 2024 оны Б/297, Б/298 тоот тушаалаар Дорнод аймгийн 8 сумын улсын бүртгэгч нарт Хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг нээлгүүлсэн. Сумдын улсын бүртгэгч нарыг хуваарь гарган хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн системд дадлагажуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Сумдад хуулийн этгээдийн 73 бүртгэл, эд хөрөнгийн 68 бүртгэл хийгдсэн байна. | 100 |
| 4.2 | Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах | - | Хүсэлт гаргаж шийдвэрлэгдсэн тоо | 1 | 2 | Аймгийн Засаг даргад төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай компьютер тоног төхөөрөмжийн судалгаа саналыг хүргүүлснээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажилд дэмжлэг үзүүлж компьютер, сканнер, принтер зэрэг тоног төхөөрөмжүүдийг шийдвэрлүүлсэн. /Үнийн дүн 34.548.400 төгрөг/<br>Хэлтэст шаардлагатай архивын нягтруулсан шүүгээний төсөв, судалгааг гарган аймгийн ЗДТГазарт хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 6.1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | - | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн | 8 | 14 | Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудсанд тавигдсан авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх уриалга бүхий 4 нийтлэл, 8 шторк, 8 видео, 4 зурагт хуудсыг байгууллагын цахим хуудас www.dornod.burtgel.gov.mn сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудсаар иргэдэд түгээн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо | | | сурталчлан ажиллав.<br>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн суралчлах зорилгоор “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар шинээр хийлгэж, мэдээллийг тухай бүр шинэчлэн ажилласан. | |
| | | | АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо | 3 | 3 | “Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад хэлтсийн 15 албан хаагчдыг хамруулж ажилласан. Хэлтсийн 22 албан хаагчдад хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглөх зааварчилгаа, зөвлөмжийг өгч 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр цахимаар хүлээн авч баталгаажуулсан. Мөн шинээр томилогдсон 4 албан хаагч, шилжин ажилласан 2 албан хаагчийн ХАСХОМ-ийг бөглүүлж баталгаажуулсан.<br>Мөн албан хаагчдыг аливаа эрсдлээс сэргийлэх зорилгоор хэлтсийн өрөө тасалгааг иж бүрэн камержуулсан. | 100 |
| **Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | |
| 7.1 | Хэлтсийн 2024 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | - | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 98 | 100 | Тус хэлтэс нь 2024 онд 4 бүлэг 17 заалт бүхий сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлант хугацаанд нийт 88 сургалтад давхардсан тоогоор 1400 албан хаагч хамрагдсан. Үүнээс:<br>• Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 34 удаагийн онлайн сургалтад /бүртгэлийн чиглэлээр-18, сонгууль-7, бусад -9/, танхимын 2 удаагийн сургалтад 2, Баян-Өлгий аймгийн бүсийн сургалтад 17 албан хаагч давхардсан тоогоор 430 албан хаагч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.<br>• Төрийн албаны зөвлөлийн /7:4:10/ 18 удаагийн, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан болон хамтарсан 36 нэр төрлийн сургалтад давхардсан тоогоор 976 албан хаагч хамрагдсан. | |
| 7.2 | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээг нэмэгдүүлэх | - | Хүний нөөцийн системын сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 17 | 25 | Хүний нөөцийн системын бие даах хичээлийг хэлтсийн 29 албан хаагч бүрэн судлаж танилцсан. | 100 |
| | | | Шалгалт өгсөн албан хаагчийн тоо | 17 | 25 | Хүний нөөцийн системд 18 албан хаагч шалгалтаа амжилттай өгч тэнцсэн. 9 албан хаагч системд нэвтэрсэн боловч шалгалтаа өгөх боломжгүй байгааг УБЕГазрын Тамгын газарт мэдэгдэж ажилласан. | |
| 7.3 | Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах | - | Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан хувь | 100 | 100 | Аймгийн ЭМГазар болон Зүүн бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран 2024 оны 3 болон 11 сард хэлтсийн 26 албан хаагчдыг эрүүл мэндийн эрт илрүүлгийн багц үзлэг болон дархлаа дэмжих эмчилгээнд хамруулж ажиллав. | 100 |




Байгууллагын нэр: **Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс**
Газар хэлтэс: **Удирдлага**
Албан тушаал: **Хэлтсийн дарга**
Овог нэр: **Дашням Оюунбаяр**
Зурсан огноо: **2024.11.25 21:24:03**

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА........................................./........................................../

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* ....................

*(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА..................................................../Т.ГАНТӨМӨР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*Тэмдэг* ....................

*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* **Нэгжийн дарга**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА....................................................../Д.ОЮУНБАЯР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*
*Тэмдэг* ....................

*(огноо)*

ГСТ7153 0723010024

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1. | Хүний нөөц, манлайллын чиглэлээр сургалтад хамрагдах | 100% | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050" сэдэвт богино хугацааны цахим сургалт, Төрийн албан хаагчдад зориулсан "Ёс зүй" цахим сургалтад тус тус хамрагдсан.<br>Мөн Удирдлагын академийн "Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт-Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сургалтад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас зохион байгуулсан "Орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах бүрэлдэхүүн, удирдах ажилтны зөвлөгөөнд" тус тус хамрагдсан. |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ................................ / Д.ОЮУНБАЯР / 2024.11.25

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

ГСТ7153 0723010024